

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**Товчилсон үгийн жагсаалт**

ҮАГ	Үндэсний аудитын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## **Агуулга**

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл .....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	14
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	18
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	18
4. Менежментийн захидал.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт..	21



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/523  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Анагаах Ухааны Хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Анагаах Ухааны Хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>212,862,560.00</u></b>	<b><u>214,261,060.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	800,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	800,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	203,818,962.00	203,818,962.00
34600	Урьдчилж гарсан зардал	203,818,962.00	203,818,962.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	9,043,598.00	9,642,098.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	579,500.00	579,500.00
35110	Тусгай зориулалттай материал	579,500.00	579,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	8,464,098.00	9,062,598.00
35410	Бичиг хэргийн материал	708,998.00	1,184,198.00
35420	Аж ахуйн материал	800,000.00	1,053,300.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,496,500.00	5,496,500.00
35440	Түлш, шатах тослох материал	130,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	1,328,600.00	1,328,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>115,545,292.43</u></b>	<b><u>113,045,468.49</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	115,545,292.43	113,045,468.49
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	113,828,792.21	112,107,968.39
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,050,000.00	33,050,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,630,750.31)	(26,935,750.35)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	507,709,110.05	519,616,170.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(406,569,442.85)	(416,159,015.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,513,577.00	18,513,577.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,993,701.68)	(16,727,013.26)
39217	Ном	750,000.00	750,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,716,500.22	937,500.10
39301	Програм хангамж	3,270,000.00	3,270,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,553,499.78)	(2,332,499.90)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>328,407,852.43</u></b>	<b><u>327,306,528.49</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>328,407,852.43</u></b>	<b><u>327,306,528.49</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	328,407,852.43	327,306,528.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	585,204,089.50	585,204,089.50
51101	Өмч: - төрийн	585,204,089.50	585,204,089.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(281,383,542.65)	(282,484,866.59)
51210	Өмнөх үеийн үр дүн	(194,498,245.92)	(281,383,542.65)
51220	Тайлант үеийн үр дүн	(86,885,296.73)	(1,101,323.94)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,587,305.58	24,587,305.58
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>328,407,852.43</u></b>	<b><u>327,306,528.49</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>712,805,040.00</b>	<b>759,933,222.24</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>11,907,060.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	11,907,060.00
120004	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	11,907,060.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>712,805,040.00</b>	<b>748,026,162.24</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	691,461,200.00	719,982,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	691,461,200.00	719,982,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,343,840.00	28,043,462.24
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,343,840.00	28,043,462.24
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>799,690,336.73</b>	<b>761,034,546.18</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>799,690,336.73</b>	<b>761,034,546.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	797,327,933.70	711,265,604.62
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	472,143,341.34	605,533,762.27
210101	Үндсэн цалин	472,143,341.34	417,265,200.27
210102	Нэмэгдэл	-	164,551,433.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	23,717,129.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,137,341.00	43,044,187.43
210201	Тэтгэврийн даатгал	41,564,321.00	18,066,350.03
210202	Тэтгэмжийн даатгал	4,951,720.00	6,327,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,948,576.00	5,061,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	812,443.00	1,265,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,860,281.00	12,323,637.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,808,179.00	9,063,300.00
210301	Гэрэл, цахилгаан	3,888,600.00	3,888,600.00
210302	Түлш, халаалт	3,269,579.00	3,374,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,650,000.00	1,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,600,232.00	6,731,408.74
210401	Бичиг хэрэг	887,700.00	229,700.00
210402	Тээвэр, шатахуун	-	130,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,907,952.00	2,216,408.74
210404	Ном, хэвлэл	2,555,000.00	3,055,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	249,580.00	1,100,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	934,000.00	1,140,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	934,000.00	1,140,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,997,200.00	-
210702	Дотоод албан томилолт	2,997,200.00	-

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	226,235,657.74	31,346,062.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225,084,157.74	29,324,062.24
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19,471,982.62	14,406,883.94
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,471,982.62	14,406,883.94
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,362,403.03	49,768,941.56
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,300,000.00	1,385,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	1,385,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	62,403.03	48,383,441.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,403.03	48,383,441.56
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(86,885,296.73)</u></b>	<b><u>(1,101,323.94)</u></b>



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>712,805,040.00</u></b>	<b><u>748,026,162.24</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>712,805,040.00</b>	<b>748,026,162.24</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	691,461,200.00	719,982,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	691,461,200.00	719,982,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,343,840.00	28,043,462.24
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,343,840.00	28,043,462.24
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>703,157,940.00</u></b>	<b><u>748,026,162.24</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>703,157,940.00</b>	<b>748,026,162.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>700,795,536.97</b>	<b>698,257,220.68</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	471,437,146.24	606,333,762.27
210101	Үндсэн цалин	405,363,946.24	418,065,200.27
210102	Нэмэгдэл	54,118,100.00	164,551,433.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,955,100.00	23,717,129.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58,758,374.73	43,044,187.43
210201	Тэтгэврийн даатгал	41,793,274.73	18,066,350.03
210202	Тэтгэмжийн даатгал	4,241,100.00	6,327,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,393,300.00	5,061,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	848,600.00	1,265,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,482,100.00	12,323,637.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,808,179.00	9,063,300.00
210301	Гэрэл, цахилгаан	3,888,600.00	3,888,600.00
210302	Түлш, халаалт	3,269,579.00	3,374,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,650,000.00	1,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,912,532.00	6,531,208.74
210401	Бичиг хэрэг	300,000.00	206,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,907,952.00	2,216,408.74
210404	Ном, хэвлэл	2,555,000.00	3,055,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	149,580.00	1,053,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	545,600.00	1,373,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	545,600.00	1,373,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,997,200.00	-
210702	Дотоод албан томилолт	2,997,200.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	152,336,505.00	31,911,762.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	151,185,005.00	29,889,762.24
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,000,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,362,403.03</b>	<b>49,768,941.56</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,300,000.00</b>	<b>1,385,500.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	1,385,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>62,403.03</b>	<b>48,383,441.56</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,403.03	48,383,441.56
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>9,647,100.00</u></b>	<b><u>-</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>9,647,100.00</b>	<b>-</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,647,100.00</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>9,647,100.00</b>	<b>-</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,647,100.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(9,647,100.00)</u></b>	<b><u>-</u></b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин Үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	585,204,089.50	24,587,305.58	(194,498,245.92)	415,293,149.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>585,204,089.50</b>	<b>24,587,305.58</b>	<b>(194,498,245.92)</b>	<b>415,293,149.16</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	(86,885,296.73)	(86,885,296.73)
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>585,204,089.50</b>	<b>24,587,305.58</b>	<b>(281,383,542.65)</b>	<b>328,407,852.43</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>585,204,089.50</b>	<b>24,587,305.58</b>	<b>(281,383,542.65)</b>	<b>328,407,852.43</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,101,323.94)	(1,101,323.94)
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>585,204,089.50</b>	<b>24,587,305.58</b>	<b>(282,484,866.59)</b>	<b>327,306,528.49</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	719,982,700.00	671,599,258.44	(48,383,441.56)	93.3
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	719,982,700.00	671,599,258.44	(48,383,441.56)	93.3
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	718,597,200.00	670,213,758.44	(48,383,441.56)	93.3
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	612,219,000.00	606,333,762.27	(5,885,237.73)	99.0
210101	Үндсэн цалин	459,859,100.00	418,065,200.27	(41,793,899.73)	90.9
210102	Нэмэгдэл	140,404,800.00	164,551,433.00	24,146,633.00	117.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,955,100.00	23,717,129.00	11,762,029.00	198.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	79,354,400.00	43,044,187.43	(36,310,212.57)	54.2
210201	Тэтгэврийн даатгал	54,045,800.00	18,066,350.03	(35,979,449.97)	33.4
210202	Тэтгэмжийн даатгал	6,327,100.00	6,327,100.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,061,700.00	5,061,700.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,265,400.00	1,265,400.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,654,400.00	12,323,637.40	(330,762.60)	97.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,063,300.00	9,063,300.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,888,600.00	3,888,600.00	-	100.0
210302	Түлш, халаалт	3,374,700.00	3,374,700.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,800,000.00	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,196,100.00	6,531,208.74	(3,664,891.26)	64.1
210401	Бичиг хэрэг	1,222,400.00	206,500.00	(1,015,900.00)	16.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,223,700.00	2,216,408.74	(7,291.26)	99.7
210404	Ном, хэвлэл	4,100,000.00	3,055,000.00	(1,045,000.00)	74.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,650,000.00	1,053,300.00	(1,596,700.00)	39.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,373,000.00	1,373,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,373,000.00	1,373,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,391,400.00	3,868,300.00	(2,523,100.00)	60.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	4,207,000.00	1,846,300.00	(2,360,700.00)	43.9

	хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	-	(59,400.00)	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	-	(100,000.00)	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	22,000.00	(3,000.00)	88.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,385,500.00	1,385,500.00	-	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,385,500.00	1,385,500.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,385,500.00	1,385,500.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	719,982,700.00	671,599,258.44	(48,383,441.56)	93.3
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	719,982,700.00	671,599,258.44	(48,383,441.56)	93.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	719,982,700.00	671,599,258.44	(48,383,441.56)	93.3
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	-	-	-	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	46	46	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	39	39	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	6	6	-	100.0
620004	Гэрээт ажилтан	-	-	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>28,043,462.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>28,043,462.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	28,043,462.24
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	28,043,462.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	28,043,462.24
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	28,043,462.24
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	28,043,462.24
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	28,043,462.24

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Анагаах Ухааны Хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Анагаах ухааны хүрээлэнгийн захирлын үүргийг гүйцэтгэгч Л.Тулгаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, худалдан авалтын анхан шатны баримтыг и баримтаар бүрдүүлж байх, төсвийн гүйцэтгэлийн тайланг алдаагүй тайлагнаж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 05-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Юнистар Аудит ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Анагаах Ухааны Хүрээлэн нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 06/144 дугаар бүхий албан бичгээр 2021 оны 01 сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Анагаах Ухааны Хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анагаах ухааны ухааны эрдэм шинжилгээ, сургалт, эмнэл зүйн тусламж үйлчилгээг хослуулан ажиллах,
- Монгол улсын анагаах ухааны хөгжил, эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудалд чиглэсэн эрдэм шинжилгээний төсөл, суурь судалгаа хийх,
- Цөм технологи, инновацын ажлыг өндөр түвшинд хийх, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх,
- Эрдэм шинжилгээний ажилтны мэргэжлийн ур чадвар, чадавхыг сайжруулах,
- Салбар хоорондын болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Анагаах Ухааны Хүрээлэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Анагаах Ухааны Хүрээлэн нь хуучнаар БСШУСЯ-ны Нягтлан бодох бүртгэлийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг гэх ба уг бодлогын баримт бичигт байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой асуудлыг бүрэн тусгаагүй

байна. Тухайлбал тус хүрээлэнд хэрэгжиж буй төслүүдийн бүртгэлийг төслийн хэрэгжилттэй уялдуулан хэрхэн яаж бүртгэхийг тусгаагүй байна.

Анагаах ухааны хүрээлэн нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд харьяа дээд газар болох Боловсрол шинжлэх ухааны яам, Шинжлэх ухаан технологийн сангаас газруудын дотоод хяналтын албанаас санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Анагаах Ухааны Хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны үр дүнгийн тайлангийн зардал 799,690.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 15,993.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурийг хэвээр авч 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 761,034.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 15,220.6 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Анагаах Ухааны Хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,101.3 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Авлага	-	800.0	800.0	-
Урьдчилгаа	203,819.0	203,819.0	-	-
Бараа материал	9,043.6	9,642.1	598.5	6.6
Үндсэн хөрөнгө	115,545.3	113,045.5	(2,499.8)	(2.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>328,407.9</b>	<b>327,306.5</b>	<b>(1,101.3)</b>	<b>(0.3)</b>
Өр төлбөр	-	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	328,407.9	327,306.5	(1,101.3)	(0.3)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>328,407.9</b>	<b>327,306.5</b>	<b>(1,101.3)</b>	<b>(0.3)</b>

Авлагын данс 800.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь нэг хүнтэй холбоотой цалингийн урьдчилгаа төлбөр барагдаагүй, 2021 онд төлөгдөх боломжтой.



Бараа материалын дансны үлдэгдэл 9,642.1 мянган төгрөг болж 598.5 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 475.2 мянга, аж ахуйн материал 253.3 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 113,045.5 мянган төгрөг болж 2,499.8 мянган төгрөгөөр буурсан нь Боловсрол Шинжлэх Ухааны Яамны хөрөнгө оруулалтаар 11,907.1 мянган төгрөгийн 6 ширхэг компьютерыг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгаж, тайлант онд 14,406.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 327,306.5 мянган төгрөг болж 1,101.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

Анагаах Ухааны Хүрээлэнгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 47,128.2 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар өссөн байна.

Төсвийн тусламж санхүүжилтийн орлого өмнөх оноос 35,221.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн болон Боловсрол Шинжлэх Ухааны Яамны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй авсан 11,907.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн орлого нь нийт орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 38,655.8 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна. Үүнд цалин нэмэгдлийн зардал 133,390.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 194,889.6 мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2019 оны 472 дугаар тогтоолыг үндэслэн Анагаах Ухааны Хүрээлэнгийн захирлын 2020 оны А/01, А/22 тоот тушаалаар ажиллагчдын цалингийн сүлжээ, нэмэгдэл, хоол унааны зардлыг шинэчлэн баталснаар цалин нэмэгдлийн зардал өмнөх оноос өссөн байна. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Анагаах Ухааны хүрээлэнгийн хэрэгжүүлж байсан 6 төслийн ажил санхүүжилтгүй болсноор бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал буурсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус хүрээлэнгийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 906,928.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 906,928.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 186,945.4 мянган төгрөгөөр бууруулж 719,982.7 мянган төгрөгөөр баталсан байна. Төсөв батлахдаа цалин нэмэгдлийн зардлыг 60,494.8 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 11,462.0 мянга, хангамж бараа материалын зардлыг 7,790.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 11,960.6 мянган төгрөгөөр тус тус бууруулж, эд хогшил урсгал засварын зардалд төсөвлөсөн 43,550.0 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тусламжийн зардалд төсөвлөсөн 36,148.6 мянган төгрөгийн зардлыг хассан байна. Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод салбарын орон тоог жил бүр 25 хувиар нэмэгдүүлнэ гэж заасны дагуу цалин, нийгмийн даатгалын зардал өсөж төлөвлөгдсөн байна. Бусад төлөвлөсөн зардлыг өмнөх жилүүдтэй харьцуулан хассан байна.

## **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 20 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 719,982.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 719,982.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 719,982.7 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 671,599.3 мянган төгрөгийг зарцуулж 48,383.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 671,599.3 мянган төгрөг буюу 93.3 хувьтай байгаа нь цалин нэмэгдлийн зардлыг 5,885.2 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 36,310.2 мянга, хангамж бараа материалын зардлыг 3,664.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 2,523.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэл дутуу байгаа нь ковид-19 цар тахалтай холбоотойгоор төр засгаас хэрэгжүүлсэн арга хэмжээний улмаас байгууллагын үйл ажиллагаа хумигдсан, зарим ажилтан зайнаас ажилласан, 2020 оны 4-9 дүгээр сард нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлсөн зэрэг нь нөлөөлсөн байна. Ковид-19 цар тахлын нөлөөг бууруулах хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлтөд их дээд сургуулиуд хамрагдсан байх ба тус хүрээлэн нь Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн харьяа байгууллага учраас чөлөөлөгдсөн байна.

## **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд Австрали улсад төвтэй Дэлхийн эрүүл мэндийн төлөөх Жорж институтээс эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтэд 28,043.5 мянган төгрөгийн орлого оржээ. Энэ санхүүжилтээр Тархины харвалтын дагах судалгааг Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт хийсэн байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн дагуу [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 154 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7,725.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Өмнөх аудитаар үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 124,520.0 мянган төгрөгийн анхны ертөг бүхий багаж хүрээлэнгийн үйл ажиллагаанд ашиглагдаагүй байхад 6,226.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан, 1,499.0 мянган төгрөгийн өндөр, жин хэмжигч зохих байгууллагын зөвшөөрөлгүй худалдан авсан зөрчлийг цаашид гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг хянаж үзэхэд тайлант онд тухайн хөрөнгөд элэгдэл байгуулаагүй, мөн үндсэн хөрөнгө худалдан аваагүй байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт			Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	хувь	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	7,725.0	2	7,725.0	100	-	-	-
Нийт дүн	2	7,725.0	2	7,725.0	100	-	-	-

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,244.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага өгч, 10,244.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой залруулга хийгдээгүй болно.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй дараах зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

1. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд байршуулбал зохих 154 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө,... жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; 6.1.2."...сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор"; 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр, 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.1.тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт; 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтуудтай нийцэхгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 10,244.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анагаах ухааны хүрээлэн нь Улсын нэгдсэн гуравдугаар эмнэлгийн байранд үйл ажиллагаа явуулдаг ба Ковид-19 цар тахлын хөл хорионд ажлын байр нь хамрагдсан, аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд бүх нийтийн хөл хорио тогтоосноос аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж, хөрөнгийн биет тооллого хийх, ажилтнуудтай уулзаж ярилцах зэрэг аудитын горимуудыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл боломж хязгаарлагдмал байсныг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Зардлын данстай холбоотой асуудал.

- 1.1. Илрүүлэлт: Байгууллагын худалдан авалтын дүнг татварын и баримтын систем дэх худалдан авалтын дүнтэй харьцуулахад 28,135.6 мянган төгрөгийн худалдан авалтаас 19,474.9 мянган төгрөгийн худалдан авалт и баримтын системд шивэгдсэн, 8,661.4 мянган төгрөгийн худалдан авалт системд шивэгдээгүй нь нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5. “татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ бүртгэх, тайланд тусгахыг хориглоно” , 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
- 1.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын шаардлага хангагдахгүй байх, улмаар төсвийн зарцуулалтад тавих хяналт сулрах эрсдэлтэй.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг e-barimt төлбөрийн цахим системд баталгаажуулж, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 заалтын дагуу хэрэгжүүлж ажиллах, цаашид худалдан авалт бүрийг e-barimt системийн төлбөрийн баримтаар баталгаажуулж байх зөвлөмж өгөв.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

##### 2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Цалингийн зардлын дүнг төсвийн гүйцэтгэлийн тайлан, үр дүнгийн тайлангийн болон нийгмийн даатгалын тайлангийн дүнгүүдтэй тулган шалгахад 1,583.2 мянган төгрөгөөр зөрсөн байна. Тодруулахад цалингийн зардал, нийгмийн даатгалын зардлын дүнг энэ дүнгээр гүйлгэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-ийг зөрчсөн, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 2.2. Эрсдэл: Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдэх, төсвийн хяналт сулрах эрсдэлтэй.
- 2.3. Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-ийг зөрчсөн, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд зардлыг зүйл ангиар зөв дүнгээр бүртгэж тайлагнаж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2021.02.21</b>	Аудитын нэр: <b>Анагаах ухааны хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>САГ-2021/93/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Анагаах ухааны хүрээлэн</b>	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	5
1	Байгууллагын худалдан авалтын дүнг татварын и баримтын систем дэх худалдан авалтын дүнтэй харьцуулахад 28,135.6 мянган төгрөгийн худалдан авалтаас 19,474.9 мянган төгрөгийн худалдан авалт и-баримтын системд шивэгдсэн, 8,661.4 мянган төгрөгийн худалдан авалт системд шивэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ бүртгэх, тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.	8,661.4	Зөвлөмж өгсөн.	Захирал Нягтлан бодогч	Л.Тулгаа Б.Нямдорж
2	Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн дагуу <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд оруулбал зохих 154 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 болон 6 дугаар зүйлийг зөрчсөн, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.		Албан шаардлага өгсөн.	Захирал Нягтлан бодогч	Л.Тулгаа Б.Нямдорж
3	Цалингийн зардлын дүнг төсвийн гүйцэтгэлийн тайлан, үр дүнгийн тайлангийн болон нийгмийн даатгалын тайлангийн дүнгүүдтэй тулган шалгахад 1,583.2 мянган төгрөгөөр зөрсөн байна. Тодруулахад цалингийн зардал, нийгмийн даатгалын зардлын дүнг энэ дүнгээр гүйлгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-ийг зөрчсөн, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1,583.2	Зөвлөмж өгсөн.	Захирал Нягтлан бодогч	Л.Тулгаа Б.Нямдорж
<b>ДҮН</b>		<b>10,244.6</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 126/АД160058

Улаанбаатар хот

САГ-2021/93/СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Анагаах ухааны хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны хуулийн дагуу тайлант хугацаанд нийт 154 мэдээлэл байршуулахаас 18 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1. тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ... жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; 6.1.2. "...сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор"; 6.1.6. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр. 6.4. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.1. тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт; 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж мэдээллийг ил тод, хуулийн хугацаанд бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаах ухааны хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэгч Л.Тулгаа, нягтлан бодогч Б.Нямдорж нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
ЮНИСТАР АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

М.ЭНХЖАРГАЛ  
Б.ТЭРБИШ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

## ТЭМДЭГЛЭЛ

A series of 28 horizontal dotted lines for writing the summary.